



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 09 сарын 21 өдөр

Дугаар А/583

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/а/, 29.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн ээлжит XXVI хуралдааны 5 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд хүүхэд залуучууд, иргэд, байгууллагуудын анхан шатны тусламжийн нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг сайжруулах, бэлтгэл, бэлэн байдлыг хангах, байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах зорилгоор жил бүр явагддаг аймгийн Засаг даргын нэрэмжит “Аврагч” тэмцээнийг анх санаачилан зохион байгуулсан Д.Тунгалаг, Б. Болдбаатар, Г.Ганбаатар, М.Мөнхбаяр нарыг тус бүр өргөмжлөл, 500000 төгрөгөөр, 10-20 жил идэвх зүтгэлтэй, тогтмол оролцож байгаа Эрдэнэтийн Дулааны цахилгаан станц ТӨХК, Эрдэнэт үйлдвэр ХХК, Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар, Эрдэнэт ус дулаан түгээх сүлжээ ОНӨХК-ийн Анхны тусламжийн нөхөрлөл тус бүрийг өргөмжлөл, хүлэмжээр, НИК- ХХК болон Боловсрол, соёл урлагийн газрын Анхны тусламжийн нөхөрлөл тус бүрийг өргөмжлөл, 1000000 төгрөгөөр шагнаж урамшуулсугай.

2. Зардалд шаардагдах 4.500.000 /дөрвөн сая таван зуун мянган төгрөг/-ийг “Гэр бүл, хүүхэд залуучуудын эрх хамгаалал, нөлөөллийн бүх төрлийн ажил, Жендэрт суурилсан арга хэмжээ”-ний зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2018 оны 09 дүгээр сарын
21 -ны өдрийн /583/ дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Нэгж үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
1	Өргөмжлөл хэвлүүлэх	50000	10	500.000
2	Шагнал/ байгууллага	1.000.000	2	2.000.000
	Шагнал /хувь хүн/	500000	4	2.000.000
3	Нийт үнэ			4.500.000

-oOo-